

Монгол Улсын 21 аймаг, Нийслэл, түүний 9 дүүргийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ) Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаад орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж байна. 2017 оны 5 дугаар сард Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгууд болон Багахангай дүүргийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ууд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 100 хувь ил тод болгожээ. ЗДТГ-уудын нийтэлсэн мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН

АЙМГУУДЫН ЗДТГ




Аймгуудын хэмжээнд 2017 оны 5 дугаар сард 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 5 аймгийн ЗДТГ 100 хувь нийтэлсэн нь өмнөх сарын дүнгээс буурсан үзүүлэлт боллоо (Тайлбар 1-ийг үзнэ үү).



НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ



2017 оны 5 дугаар сард Нийслэл, дүүргийн хэмжээнд 5 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ зөвхөн нэг дүүргийн ЗДТГ 100 хувь ил болгожээ (Тайлбар 1-ийг үзнэ үү).



Дүн мэдээнд хамаарах тайлбар:

Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн тухайн сард хамаарах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйлгээг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий залруулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн мониторингийн дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас
- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Сангийн яамны Төрийн сангийн дансны хуулга